

БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ТООН КОНТЕНТ, ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН БОДЛОГО ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
ЛУВСАНДОРЖ ОВОГТОЙ НАРМАНДАХЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
Зорилт 1. “Харилцаа холбоо, шуудан, өргөн нэвтрүүлгийн хөгжлийн бодлого, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бодлогын удирдамжаар хангана”							
1.	Арга хэмжээ 1.1. Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэх	Арга хэмжээний тоо	0	2	1. Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахтай холбоотой асуудлаар болон өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдэд тулгарч буй асуудлуудын талаар санал солилцох уулзалтыг Арилжааны телевизүүдийн холбооны төлөөллүүдтэй 2024 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр, Монголын телевизүүдийн холбоо, Орон нутгийн телевизүүдийн холбоо, Олон суваг дамжуулагч үйлчилгээ эрхлэгчдийн холбоотой 2024 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр тус тус уулзалт зохион байгуулав. Уулзалтад дэд сайд Ж.Эрхэмбаатар, Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Цагаанхүү, Бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн Л.Нармандах, Шуудан, өргөн нэвтрүүлгийн хэлтсийн шинжээч Э.Оюун-Эрдэнэ нар оролцов. 2. Ерөнхийлөгчийн тамгын газраас “Эрүүл монгол хүн” үндэсний хөтөлбөрийн хүрээнд “Эрүүл мэндийн өргөн нэвтрүүлгийн өнөөгийн байдал, эрх зүйн зохицуулалтад санал оруулах нь” сэдэвт хэлэлцүүлгийг 01 дүгээр сарын 25-нд зохион байгуулсан ба тус хэлэлцүүлэгт дэд сайд Ж.Эрхэмбаатар, тус газрын мэргэжилтэн Л.Нармандах нар оролцож холбогдох судалгааны ажилтай танилцан, хууль эрх зүйн орчныг сайжруулах талаар санал солилцов. Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах, эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, олон нийтээр төслийг хэлэлцүүлэхэд дэмжлэг үзүүлэх	01.10 12.10	100

					ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Сайдын 2024 оны 11 дүгээр сарын ... өдрийн А/50 дугаар тушаалаар байгуулсан. Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулахтай холбоотой асуудлын жагсаалт болон боловсруулсан төслийн талаарх мэдээллийг бэлтгэн 12 дугаар сарын 05-ны өдөр Ажлын хэсгийн дарга М.Тулгат болон ажлын хэсгийн зарим гишүүдэд танилцуулав.		
2.	Арга хэмжээ 1.2. Өргөн нэвтрүүлгийн талаар баримтлах бодлогын чиглэлийг батлуулна.	Батлуулсан баримт бичгийн тоо	0	1	Бүгд Найрамдах Солонгос Улсын Мэдээллийн нийгмийн хөгжлийн институт (KISDI)-тэй "Монгол улсын өргөн нэвтрүүлгийн бодлого боловсруулах" зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд Монгол улс болон олон улсын өргөн нэвтрүүлгийн хууль, эрх зүйн орчин, бодлогын судалгааг хийлгэж тайлангийн төслийг 2024 оны 07 дугаар сарын 26-нд хүлээн авсан.	01.10 12.10	70
3.	Арга хэмжээ 1.3. "Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн батлах тухай" тогтоолын төслийг боловсруулж, төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх	Төслийн тоо	0	1	"Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн батлах тухай" тогтоолын төслийг боловсруулан, Засгийн газрын гишүүдээс санал авахаар 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 01/377 дугаар албан бичгийг нийт 20 байгууллагад хүргүүлсэн. Нийт 20 байгууллагаас ирсэн саналыг нэгтгэн, тогтоолын төсөлд тусгаж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр тогтоолын төсөл, танилцуулга холбогдох материалын хамт 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 01/823 дугаар албан бичгээр Засгийн газрийн Хэрэг эрхлэх газарт хүргүүлэн, 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлсэн. Тус хуралдаанаас олон нийтийн радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох асуудлыг "Олон нийтийн радио, телевизийн тухай хууль"-д нэмэлт өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх нь зүйтэй гэсэн тэмдэглэл гарсны дагуу тус яамнаас 2024 оны 10 дугаар сарын 23-нд Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийлгэх зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулан, хамгийн бага үнийн санал ирүүлсэн Оюуны-инноваци НҮТББ-тай гэрээ байгуулахаар Төрийн нарийн бичгийн даргын "Гэрээ байгуулах, зардал гаргах тухай" А/92 дугаар тушаал батлуулсан. Тус байгууллагатай 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн Ү/06 дугаартай гэрээ байгуулан ажиллаж байна.	02.10 12.10	100

4.	Арга хэмжээ 1.4. Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн дүрэм, сан бүрдүүлэх, сангийн хөрөнгийг зарцуулах журмыг шинэчлэн боловсруулж, төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх	Төслийн тоо	0	1	Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг эхлүүсэнтэй холбоотойгоор Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар болон Монголын арилжааны телевиүүдийн холбооны 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 01/68 дугаар, Монголын олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн холбооны 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 01/11 дугаар албан бичгээр ирүүлсэн саналыг үндэслэн Засгийн газрын 2023 оны 364 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн дүрэм, сан бүрдүүлэх, сангийн хөрөнгийг зарцуулах журамд өөрчлөлт оруулан, шинэчилсэн журмын төслийг боловсруулж, Засгийн газрын гишүүд, холбогдох байгууллага болох нийт 26 байгууллагаас санал авахаар сайдын 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 01/768 дугаар албан бичгийг хүргүүлэн санал авсан ба Засгийн газрын хэрэг эрхлэх газраас дэмжигдээгүй тул төслийг дахин боловсруулахаар болсон. Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн дүрэм, сан бүрдүүлэх, сангийн хөрөнгийг зарцуулах журамд нэмэлт, өөрчлөлт оруулах Засгийн газрын тогтоолын төслийг дахин боловсруулан Засгийн газрын гишүүд, холбогдох байгууллагаас сайдын 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 01/581 дугаар албан бичгийг хүргүүлэн нийт 19 байгууллагын саналыг нэгтгэн тусгаж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 01/890 дугаартай албан бичгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Тус тогтоолын төсөл нь 2024 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан.	02.10 12.04	100
5.	Арга хэмжээ 1.5. Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн хэрэгжилтийг хангах	Ажлын хэсэг болон сонгон шалгаруулалтын ажилд ажилласан тоо	0	2	Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/30 дугаар тушаалаар баталсан Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулах, ажлын хэсгийн орж дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд: 1. Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төсөлд санал өгөв. 2. Сонгон шалгаруулалтын үнэлгээний шалгуур үзүүлэлт, ажлын даалгаварыг ажлын хэсгийн гишүүдийн хамт боловсруулав. 3. Ажлын хэсгийн хуралд 2024 оны 3, 4 дүгээр сард нийт 4 удаа оролцов. 4. Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн хэрэгжилтэд Авилгатай тэмцэх газраас шалгалт орсны улмаас хэрэгжилт	01.10	100

					зогссон бөгөөд Авлигатай тэмцэх газрын 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдөр ирүүлсэн зөвлөмжийг үндэслэн Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн дүрэм журамд өөрчлөлт оруулан 2024 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан.		
Зорилт 2. "Бүх нийтийн тоон бичиг үсгийн чадавхыг сайжруулах үйл ажиллагааг бодлогын удирдамжаар хангана"							
6.	Арга хэмжээ 2.1. Бүх нийтийн цахим ур чадварын бүтцийн хүрээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.	Төслийн тоо	0	1	"Бүх нийтийн цахим ур чадварын бүтцийн хүрээ батлах тухай" Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулга, холбогдох материалыг боловсруулж, төсөлд санал авахаар Засгийн газрын гишүүд, Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академи, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, И-Монгол академид 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/153 дугаар албан бичгийг хүргүүлсэн. Засгийн газрын тогтоолын төсөлд Засгийн газрын гишүүдээс ирүүлсэн саналыг нэгтгэн, холбогдох материалуудын хамт Засгийн газрын хэрэг эрхлэх газарт 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 01/401 дугаар албан бичгээр хүргүүлсэн. "Бүх нийтийн цахим ур чадварын бүтцийн хүрээг 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн Засгийн газрын 141 тогтоолоор батлуулсан.	01.10	100
7.	Арга хэмжээ 2.2. Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон Пипл ин Нийд ОУТББ-ын хооронд 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан Хамтран ажиллах санамж бичгийн хэрэгжилтийг хангах	Зохион байгуулсан болон оролцсон арга хэмжээний тоо	0	2	Пийпл Ин Нийд ОУТББ, Фаро фаундэйшн ТББ-тай 2023 оны 05 дугаар сарын 29-нд байгуулсан санамж бичгийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд: 1. Пийпл иннийд ТББ-тай хамтран хэрэгжүүлж байгаа "Иргэний нийгмийн байгууллагыг чадавхжуулах замаар цахим оролцоог нэмэгдүүлэх нь" (DICE) төслийн хурал 3 дугаар сарын 13, 4 дүгээр сарын 12-нд тус тус зохион байгуулагдсан бөгөөд Сайдын зөвлөх С.Тэнгис, тус газрын мэргэжилтэн Л.Нармандах нар оролцож төслийн явц, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөтэй танилцан төслийн хүрээнд хэрэгжүүлэх бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөр, агуулгыг хэлэлцэв. 2. Мөн энэхүү төслийн хүрээнд 3 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулагдсан Иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллүүдтэй уулзах өглөөний уулзалтад оролцож тус яамнаас цахим шилжилттэй холбоотой авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ болон "Бүх нийтийн цахим ур чадвар, чадамжийн бүтцийн хүрээ"-г танилцуулан, мэдээлэл өгөв. 3. Мөн 2020 оны Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Бүх нийтийн үүргийн сан, Шинжлэх ухаан технологийн их сургууль, Монгол Улсын их сургууль хамтран эрхлэн	01.10	100

					гаргасан "Харилцаа холбоо, мэдээллийн технологийн нэр томъёоны толь бичиг"-ийг баяжуулан, цахим шилжилт, цахим ур чадвартай холбоотой 400 гаруй нэр томъёоны орчуулга болон тайлбарыг боловсруулан People In Need Mongolia ТББ-д хүргүүлсэн.		
Зорилт 3. "Төрийн албаны чиг үүргийг хэрэгжүүлнэ"							
8.	Арга хэмжээ 3.1. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу хөтлөх нэрийн жагсаалтад заасан баримт бичгийг хугацаанд нь бүрэн архивлана.	Архивт хүлээлгэн өгсөн баримт бичгийн тоо	-	2	1. Бодлого, төлөвлөлтийн газрын 2023 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг газрын хэмжээнд нэгтгэн боловсруулж Төрийн захиргааны удирдлагын газрын Архив-бичиг хэргийн мэргэжилтэн Ш.Золбаярт хүргүүлсэн. 2. Яамны 2023 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад туссан Бүх нийтийн цахим ур чадварын бүтцийн хүрээг батлуулахтай холбоотой баримт бичиг, БНСУ-ын KISDI байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн "Монголын өргөн нэвтрүүлгийн талааарх бодлогын судалгаа"-ш хадгаламжийн нэгж үүсгэн архивт 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр хүлээлгэн өгсөн.	01.10	100
9.	Арга хэмжээ 3.2. Хувийн ашиг сонирхол болон хөрөнгө оруулалтын мэдүүлэг гаргах	ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд гаргасан эсэх	-	ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд гаргасан байна	Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг зааврын дагуу гарган 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдөр баталгаажуулсан.	01.10	100
10.	Арга хэмжээ 3.3. Төрийн жинхэнэ албан хаагчийн төлөвлөгөө боловсруулж, нэгжийн удирдлагаар баталгаажуулах	Төлөвлөгөөний биелэлтийг батлагдсан загварын дагуу сар бүр тайлагнаж, удирдлагаас чиглэл авсан байна.	-	Төлөвлөгөөг холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, нэгжийн удирдлагаар батлуулсан байна	Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулсан. Өөрийн болон нэгжийн гүйцэтгэлийн тайланг хагас, бүтэн жилээр хугацаанд нь гарган тайлагнасан.	01.10	100
11.	Арга хэмжээ 3.4. Удирдлагаас хуваарилсан албан бичгийг шийдвэрлэх, хариуцсан ажлын чиглэлээр албан бичиг боловсруулж, стандартын дагуу гаргах	Ирсэн албан бичгийг хугацаандаа шийдвэрлэсэн эсэх	-	Албан бичиг хугацаанд нь шийдвэрлэсэн байна	1. Бодлого, төлөвлөлтийн газрын 1, 2, 3 дугаар сарын тайланг нэгтгэн боловсруулж, тухай бүрд нэгтгэн Төрийн захиргааны удирдлагын газрын холбогдох албан хаагчид цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлсэн. 2. Бодлого, төлөвлөлтийн газрын 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг нэгтгэн боловсруулж, хүргүүлсэн.	01.10	100

					3. Тайлант хугацаанд нийт 145 албан бичиг хугацаанд нь шийдвэрлэж, 49 бичиг боловсруулан илгээсэн. Тайлант хугацаанд иргэд, олон нийтээс өргөдөл гомдол ирээгүй байна.		
--	--	--	--	--	--	--	--

Гурав. Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Үүрэг даалгавар 1. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээнд захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалтад дүн шинжилгээ хийх, тухайн харилцааг хуулиар зохицуулах шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах дэд ажлын хэсэгт ажиллах	Төслийн тоо	0	1	Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/21 дүгээр тушаалаар "Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээнд хуулиар захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалтад дүн шинжилгээ хийх, тухайн харилцааг хуулиар зохицуулах шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах" үүрэг бүхий Дэд ажлын хэсгийн 5 удаагийн хуралд оролцсон. Ажлын хэсгийн хүрээнд өргөн нэвтрүүлгийн чиглэлийн 2 актыг Өргөн нэвтрүүлгийн тухай хуулинд тусгахаар хуулийн төслийг боловсруулсан.	02.10	100
2.	Үүрэг даалгавар 2. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд санал боловсруулах	Саналын тоо	0	3	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд өргөн нэвтрүүлгийг хөгжүүлэх талаар 3 санал тусгасан. Тус яамнаас нийт 26 зорилтын хүрээнд 69 арга хэмжээг төлөвлөн, төслийг ЭЗХЯ-ны Ажлын хэсэгт хүргүүлсэн.	10.10 10.29	100
3.	Үүрэг даалгавар 3. Гадаад айлчлал, уулзалтад ярианы сэдэв бэлтгэх	Бэлтгэсэн ярианы сэдвийн тоо	0	2	Тус яамны сайд Н.Учрал Арабын Нэгдсэн Эмират Улсын Дубай хотноо зохион байгуулагдсан "Дэлхийн засгийн газруудын дээд түвшний уулзалт"-ын хүрээнд: b. Арабын Нэгдсэн Эмират Улсын Хиймэл оюун ухаан, цахим эдийн засаг, зайны хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан Төрийн сайд бөгөөд Ерөнхий сайдын ажлын албаны Ерөнхий захирал Омар бин Султан Аль-Оламатай хийх ярианы сэдэв бэлтгэсэн. c. Арабын Нэгдсэн Эмират Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын сайд Мухаммад Абдулла Аль-Геравитай уулзах ярианы сэдэв бэлтгэсэн. d. Ц.Баатархүү сайдын Канад Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Сандра Шуфани болон Bell helicopters компани, BlackBerry компанийн төлөөлөлтэй уулзах ярианы сэдэв;	02.01	100

4.	Үүрэг даалгавар 4. Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Нэгдсэн үндэсний байгууллагын Хүүхдийн Сантай 2024-2027 онд хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлуулах	Батлуулсан төлөвлөгөөний тоо	0	1	Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Нэгдсэн үндэсний байгууллагын Хүүхдийн Сантай хамтран 2024-2027 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Сайд Н.Учрал, НҮБ-ын Хүүхдийн Сангийн суурин төлөөлөгч Эваристе Коуасси-Комлан нар гарын үсэг зурах үйл ажиллагааг 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулсан.	02.15	100
5.	Үүрэг даалгавар 5. Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон Пипл ин Нийд ОУТББ-ын хооронд 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан Хамтран ажиллах санамж бичгийн хэрэгжилтийг хангах	Боловсруулсан төслийн тоо	0	1	Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон Пипл ин Нийд ОУТББ-ын хооронд 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан Хамтран ажиллах санамж бичгийн байгуулсан. Энэ хүрээнд 2020 оны Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Бүх нийтийн үүргийн сан, Шинжлэх ухаан технологийн их сургууль, Монгол Улсын их сургууль хамтран эрхлэн гаргасан "Харилцаа холбоо, мэдээллийн технологийн нэр томъёоны толь бичиг"-ийг баяжуулан, цахим шилжилт, цахим ур чадвартай холбоотой 400 гаруй нэр томъёоны орчуулга болон тайлбарыг боловсруулан People In Need Mongolia ТББ-д хүргүүлсэн.	04.20 05.27	100
6.	Үүрэг даалгавар 6. Нэгдсэн Үндэстний Байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлж буй "Төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, олон нийтийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх (DEMOSC)" төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	0	2	Тус яамны сайдын 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/34 дүгээр тушаалаар Төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, олон нийтийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх (DEMOSC) төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сантай хамтран ажиллах үүрэг бүхий Ажлын хэсгийн нарийн бичгээр ажиллан төслийн 1 болон 3 дугаар үйл ажиллагаад дараах байдлаар оролцсон. 1.Гарц 1. Цахим ур чадварын сургалтын төв, төрийн үйлчилгээний хөдөлгөөнт цэг байгуулах ажлын хүрээнд тус төслийг Дархан-Уул аймагт хэрэгжүүлэхээр хэлэлцэн төсл хэрэгжүүлэх газар, автомашины техникийн нөхцөлтэй танилцан гэрээ байгуулах бэлтгэл ажлыг хангасан. 2.Гарц 3. Олон нийтийн цахим мэдээллийн ажилтан бэлтгэх туршилтын төслийг удирдлагаар хангах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: Олон нийтийн цахим мэдээллийн ажилтан бэлтгэх туршилтын төслийг удирдлагаар хангах ажлын хэсгийн 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн уулзалтад оролцож сургагч багш буу ЕБС-ын мэдээлэл зүйн багш нарт зориулсан сургалтын агууллагын талаар хэлэлцэж санал солилцсон.	05.16 12.10	100
7.	Үүрэг даалгавар 7. Тус яам, газрын хийж хэрэгжүүлж байгаа ажлын талаар	Танилцуулга	0	2	1. Хүний эрхийн комиссоос 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулсан "Цахим эринд хүний эрхэд	01.10 12.10	100

	гадаад, дотоодын арга хэмжээнд илтгэл, танилцуулга бэлтгэх	илтгэлийн тоо			суурилсан хөгжлийг дэмжих нь" симпозиумд тус яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэгийн танилцуулах "Цахим засаглал, цахим шилжилтийн үйл явц" илтгэлийг бэлтгэсэн. 2. Цахим шилжилтийн бэлэн байдлыг хангах, төрийн цахим үйлчилгээг олон нийтэд таниулан сурталчлах зорилгоор төрийн үйлчилгээний байгууллагуудтай хамтран "Цахим ур чадвар" аяны нээлтийн хүрээнд нээлттэй хаалганы өдөрлөгийг 2024 оны 04 дүгээр сарын 27-нд Чингэлтэй дүүрэгт зохион байгуулсан. Төрийн нарийн бичгийн даргын нээлтийн үг, "Цахим хөгжлийн бодлого" сэдэвт танилцуулгыг бэлтгэсэн.		
8.	Үүрэг даалгавар 8. Дэлхийн банкны дэмжлэгээр хэрэгжиж буй "Ухаалаг засаг-2" төслийн үнэлгээний хороонд ажиллах	Үнэлгээний хороонд ажилласан тоо	0	1	Дэлхийн банкны дэмжлэгээр хэрэгжиж буй "Ухаалаг засаг-2" төслийн Дижитал (тоон) хуваагдлыг бууруулах дэд төслийн хүрээнд ахмад настанд чиглэсэн сургалт болон таниулан сурталчлах арга хэмжээ зохион байгуулах зөвлөх үйлчилгээний үнэлгээний хороонд ажиллаж 4 зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтын үнэлгээг хийж гүйцэтгэв.	4.10	100
9.	Үүрэг даалгавар 9. "Go Mongolia" уриан дор зохион байгуулагдсан Монголын Эдийн Засгийн Чуулган 2024 арга хэмжээний зохион байгуулалтад орж ажиллах	Арга хэмжээний тоо	0	1	"Go Mongolia" уриан дор зохион байгуулагдсан Монголын Эдийн Засгийн Чуулган 2024 арга хэмжээг 7 дугаар сарын 8, 9-ний өдрүүдэд зохион байгуулахад Эдийн засаг, хөгжлийн яамтай хамтран чуулганы салбар хуралдаан болох "Дижитал засаглал ба дижитал эдийн засаг-гаргасан ахиц" сэдвээр хэлэлцүүлгийн ярилцах сэдэв, холбогдох бэлтгэл ажлыг хангахад оролцсон.	07.01 07.09	100
10.	Үүрэг даалгавар 10. Ажлын даалгавар боловсруулах, худалдан авах ажиллагааг зохион байгуулах	Ажлын даалгавар ын тоо	0	4	Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн А/38 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны урсгал зардлын хөрөнгөөр 2024 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөө"-нд заасан ажлыг хэрэгжүүлэх хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: 1."Өргөн нэвтрүүлгийн контент мониторинг судалгаа"-ны ажлын даалгаврыг батлуулан сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулан хамгийн бага үнийн санал ирүүлсэн Гоё монголын төлөө НҮТББ-тай гэрээ байгуулахаар Төрийн нарийн бичгийн даргын "Гэрээ байгуулах, зардал гаргах тухай" А/87 дугаар тушаал батлуулан, тус байгууллагатай 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн Y/05 дугаартай гэрээ байгуулан гэрээний хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.	10.05 12.10	100

					2.“Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх” ажлын даалгаврыг батлуулан сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулан хамгийн бага үнийн санал ирүүлсэн Оюуны-инноваци НҮТББ-тай гэрээ байгуулахаар Төрийн нарийн бичгийн даргын “Гэрээ байгуулах, зардал гаргах тухай” А/92 дугаар тушаал батлуулан, тус байгууллагатай 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн Ү/06 дугаартай гэрээ байгуулан гэрээний хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. 3.“Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох” ажлын даалгаврыг батлуулан сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулан хамгийн бага үнийн санал ирүүлсэн Номуун ирээдүй төв НҮТББ-тай гэрээ байгуулахаар Төрийн нарийн бичгийн даргын “Гэрээ байгуулах, зардал гаргах тухай” А106 дугаар тушаал батлуулан, тус байгууллагатай 2024 оны 11 дугаар сарын 06-ны өдрийн Ү/08 дугаартай гэрээ байгуулан гэрээний хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. 4.“Их өгөгдөл (big data), хиймэл оюун ухаан (AI)-ыг хөгжүүлэх стратеги төлөвлөгөөний төсөл боловсруулах” ажлын даалгаврыг батлуулан сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулан хамгийн бага үнийн санал ирүүлсэн Элбэг ирмүүн ХХК-тай гэрээ байгуулахаар Төрийн нарийн бичгийн даргын “Гэрээ байгуулах эрх олгох, зардал гаргах тухай” А/121 дугаар тушаал батлуулан, тус байгууллагатай 2024 оны 11 дугаар сарын 22-ны өдрийн Ү/09 дугаартай гэрээ байгуулан гэрээний хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.		
11.	Үүрэг даалгавар 11. “Төрийн байгууллагад мэдээлэл технологийн чиглэлээр ажиллах албан тушаалтны чиг үүрэг, мэргэжил, мэргэшлийн тогтоох” чиглэлээр санал боловсруулан хүргүүлэх	Хүргүүлсэн баримтын тоо	0	1	Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 09 дүгээр сарын 23-н өдрийн А/45 дугаар тушаалаар Төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн хүний нөөцийн бүрдүүлэлт, чиг үүрэг, сургалт хөгжлийн бодлогын хэрэгжилт, үр дүнд хүний нөөцийн аудит хийх багт мэргэжлийн чиглэлээр дэмжлэг үзүүлэх ажлын хэсэгт орж ажиллан “Төрийн байгууллагад мэдээлэл технологийн чиглэлээр ажиллах албан тушаалтны чиг үүрэг, мэргэжил, мэргэшлийн тогтоох” чиглэлээр санал боловсруулан 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 03/969 дугаартай албан бичгээр Төрийн албаны зөвлөд хүргүүлэв.	09.23 11.22	100
12.	Үүрэг даалгавар 12. “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын биелэлт нэгтгэн гаргах	Биелэлтийн тоо	0	1	Тус газраас “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын биелэлтийг 2020 оноос хойш хугацаагаар гарган нотлох баримтын хамт 09 дүгээр сарын 10-ны өдөр Төрийн захиргааны удирдлагын газарт munkhsarnai@mddic.gov.mn хаягаар хүргүүлэв.	09.01 09.10	100

13.	Үүрэг даалгавар 13. Төрийн бүтээмжийн Үндэсний хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд санал боловсруулан хүргүүлэх	Хүргүүлсэн баримтын тоо	0	1	Төрийн бүтээмжийн Үндэсний хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд оруулах арга хэмжээний саналыг "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилтын 5.3, "Шинэ сэргэлтийн бодлого"-ын 6.1 болон "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.3-т заасан чиглэлээр боловсруулж 11 дүгээр сарын 27-ны өдөр ncsp@cabinet.gov.mn хаягаар хүргүүлсэн.	11.10 11.27	100
14.	Үүрэг даалгавар 14. "Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратегийн хэлэлцүүлэг"-ийн арга хэмжээг зохион байгуулах	Арга хэмжээний тоо	0	1	1."Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратегийн хэлэлцүүлэг" зохион байгуулах ажлын хүрээнд Ажлын хэсгийн тушаалын төсөл, хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын төлөвлөгөө, төсвийн төслийг боловсруулан Сайдын зөвлөхөд танилцуулсан. 2.НҮБ-ын эдийн засаг, нийгмийн асуудал хариуцсан газартай хамтран "Монгол Улсын Үндэсний өгөгдлийн засаглал болон Дижитал засаглал" олон улсын хурлыг 12 дугаар сарын 3-4-ны өдрүүдэд зохион байгуулсан ба тус арга хэмжээний мандат хэлвэх, тараах, хөтөлбөр хэвлэн тараах, зочид угтах зэрэг зохион байгуулалтын ажилд оролцов.	11.11 12.03	100
15.	Үүрэг даалгавар 15. Радио, телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын үйл ажиллагаатай танилцах	Арга хэмжээний тоо	0	1	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү болон яамны холбогдох албан хаагчид 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр Радио, телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын үйл ажиллагаатай танилцан Радио нэвтрүүлэх төв станцад очиж ажилласан бөгөөд бүрэлдэхүүнд тус газрын мэргэжилтэн Л.Нармандах орж ажилласан.	09.05	100

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			3	4			
1.	Арга хэмжээ 1. Хариуцсан ажлын чиглэлээр байгууллагаас болон бусад газраас зохион байгуулсан сургалт, семинарт оролцох	Хамрагдсан сургалтын тоо	0	3	1. Удирдлагын академиас зохион байгуулж буй Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 2024 оны 09 дүгээр сарын 20-оос 12 дугаар сарын 13-ны хооронд суралцаж багаа бөгөөд 12 дугаар сарын 25-нд нэгсдэн шалгалтаа өгч төгсөнө. 2.Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг 7:4:10 сургалтад тогтмол хамрагдсан. 3. Авлигатай тэмцэх газраас "Авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ухуулан сурталчлах ажлыг тасралтгүй явуулах, олон нийтийн авлигын	01.10 12.10	100

				талаарх мэдлэгийг дээшлүүлэх, түүнтэй тэмцэх арга барилд сургах" цахим сургалтад хамрагдсан. 4. Ухаалаг Засаг- 2 төслийн хүрээнд хэрэгжүүлж буй Ахмад настай иргэдийн дижитал ур чадварыг нэмэгдүүлэх төслийн үнэлгээний хорооны гишүүний сургалтад хамрагдав. 5. Монголын программ хангамж үйлдвэрлэгчдийн Холбооноос зохион байгуулсан "Дижитал эрин үеийн өрсөлдөөний бодлого, хөгжүүлэлт" сэдэвт богино хугацааны сургалтад хамрагдсан. 6. Эдийн засгийн хөгжлийн яам, Монгол улс дахь Нэгдсэн үндэсний байгууллагатай хамтран 9 дүгээр сарын 06-нд зохион байгуулсан "Тогтвортой хөгжлийн зорилго-Үндэсний хэлэлцүүлэг"-т тус газрын мэргэжилтэн Л.Нармандах оролцож "Тогтвортой хөгжлийн зорилгод инноваци, технологи ашиглах нь" дэд сэдвийн хүрээнд багаар ажиллан санал солилцов.		
--	--	--	--	--	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

Тоон контент, өргөн нэвтрүүлгийн бодлого
хариуцсан мэргэжилтэн
(Албан тушаал)

.....
Л.Нармандах
(Нэр, гарын үсэг)

2024.12.06
.....
(Огноо)